

## **Арбитрын байгууллагын үүсэл**

1940-10-11-энд Сайд нарын Зөвлөлийн дэргэд “Албан газрын хоорондын зарга тэмцлийг таслан шийтгэх хэлтэс” гэсэн нэрээр арбитрын байгууллага анх үсч байгуулагдсан байна.

1940-11-12-онд тус газрын шинэ дүрэм батлагдахад Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх улсын арбитр гэж батлагджээ. 1960 онд Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор сайд нарын Зөвлөлийн дэргэдэх улсын арбитрын газар болгон өөрчилжээ.

1965-6-16-онд сайд нарын Зөвлөлийн 218 дугаар тогтоолоор аймаг, хотын арбитрыг 1965-7-1-нээ эхлэн байгуулж, түүний үүргийг аймаг хотын шүүхийн дарга нарт хариуцуулахаар тогтоож, дүрмийг баталжээ.

1977-1-21-энд сайд нарын Зөвлөлийн 24-р тогтоолоор аймаг, хотын арбитрыг улсын арбитрын газарт шууд харьяалуулан аймаг, хотын гүйцэтгэх захиргаанд дэргэдэх улсын арбитр болгон өөрчлөн байгуулахаар тогтоожээ.

1977-2-11-энд Сайд нарын Зөвлөлийн 40-р тогтоолоор аймаг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрын дүрмийг баталж, арбитрын үүргийг аймаг, хотын шүүхийн даргад хавсруулан гүйцэтгүүлж байхаар тогтоожээ.